



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

XXXIX ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хурлыг 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 13:00 цагт Төрийн ордон дахь "Орон нутгийн удирдлага"-ын танхимд 87.3 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар /Ковид19/-ын нөхцөл байдлын мэдээлэл;

Эрүүл мэндийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

2. Нийслэлийн хэмжээнд Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай;

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

бригадын генерал Г.Ариунбуян,

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

бригадын генерал Г.Ариунбуян,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар нарт.

1.1. Нийслэлийн хэмжээнд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 06:00 цагаас 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх Улсын онцгой комиссын шийдвэрийг Засгийн газрын хуралдаанд танилцуулах,

Хоёр. Засгийн газар, Улсын онцгой комиссын гишүүд, агентлагийн дарга,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар нарт.

2.1. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэнтэй холбогдуулан төрийн захиргааны байгууллагын ажилтан, албан хаагчдын 10-15 хүртэлх хувийг ажлын байранд нь ажиллуулж, бусад ажилтан албан хаагчдыг гэрээсээ цахимаар ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авах,

Гурав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн, З.Мэндсайхан

Эрчим хүчний сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Тавинбэх,

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Г.Ёндон,

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн захирал Д.Нямхүү нарт:

3.1. Хүнс, түлш, эрчим хүч, нефть, шатахуун, эм, эмнэлгийн хэрэгслийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэх, хангамжийг нэмэгдүүлж тогтвортой байдлыг хангах,

Дөрөв. Аймаг, нийслэлийн Засаг дарга,
Онцгой комиссын дарга нарт:

4.1. Мэргэжлийн байгууллага, тусгаарлан ажиглах байрнаас гарч гэрийн ажиглалтад шилжсэн иргэдийн зорчих хөдөлгөөнийг "CLIX GPS" систем ашиглан цахим хэлбэрээр хяналт тавих ажлыг зохион байгуулах арга хэмжээг авах,

Тав. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Болор-Эрдэнэд:

5.1. "CLIX GPS" системд мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх, тайлан, мэдээллийг харах эрхийг эрх бүхий байгууллагад үүсгэж өгөх, сургалт зохион байгуулж, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг авч ажиллах.

ДАРГА  Я.СОДБААТАР
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА  Т.МӨНХДОРЖ